



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Солонго дулааны станц ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/13/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn Аудитор: С.Санчирмаа Утас: 99282488 Цахим хаяг: sanchirmaas@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024. 03. 15 № 121

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Солонго дулааны станц ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийг эс зөвшөөрвөл Солонго дулааны станц ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар нийгмийн даатгалд ажилчдын цалинг зөрүүтэй тайлагнасан, авлага, өглөгийн үлдэгдэл болон хоорондын тооцоо нийлээгүй, нүүрсний зарцуулалтын анхан шатны баримт нь нярвын тайлангаас зөрүүтэй, нүүрсний анхан шатны баримтын бүрдэл буюу нэхэмжлэх, падаангүй зэрэг 290,811.8 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 41.12.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1, 13.7, 20.2.4, 20.2.5, 20.2.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 43.2.1, 109.3, 109.8, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1 заалттай тус тус нийцэхгүй, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2023 оны тогтоолоор халаалтын тариф шинэчлэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Борлуулалтын орлого өмнөх оноос 486,311.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 5 зорилт 40 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 36 арга хэмжээг бүрэн, 4 арга хэмжээ биелээгүй буюу нийт дүнгээр 83.4 хувиар биелэлтийг хүргүүлсэн боловч ажлын дүгнээгүй байна.

0702700386

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	267,336.9	408,047.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	9,866,557.9	9,695,567.6
	Нийт хөрөнгийн дүн	10,133,894.8	10,103,615.0
	Нийт өр төлбөрийн дүн	304,055.1	285,244.8
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,829,839.7	9,818,370.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,133,894.8	10,103,615.0
	Үйл ажиллагааны орлогын дүн	(285,193.5)	201,118.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	152,966.8	177,387.5
	Үйл ажиллагааны үр дүн	(438,160.3)	23,730.5
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	35,200.0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(438,160.3)	(11,469.5)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,268,000.0	9,829,839.7
	Тайлант оны үр дүн	(438,160.3)	(11,469.5)
	Эцсийн үлдэгдэл	9,829,839.7	9,818,370.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	919,431.9	1,286,603.3
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	901,284.1	1,241,962.4
	Үйл ажиллагааны ЦМГ	18,147.7	44,640.8
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(16,969.2)	(7,085.4)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	(37,200.8)
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	1,178.5	354.6
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	646.7	1,825.2
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,825.2	2,179.8
Зорилтод түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл			
	Нийт орлого	1,287,280.0	1,238,616.4
	Нийт зардал	1,442,129.0	1,254,885.9
	Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	(154,849.0)	(16,269.5)
	Орлогын албан татвар	-	-
	Татварын дараах ашиг алдагдал	(154,849.0)	(16,269.5)

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 85,651.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой: Нягтлан бодох бүртгэлд биет бус хөрөнгийг 4,800.0 мянган төгрөгийн зөрүүтэй бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах," гэж заасныг зөрчсөн байна.

Хууль тогтоомжтой холбоотой: Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд 80,851.8 мянган

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

төгрөгийг дутуу шивсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэж заасныг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 290,811.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 290,811.8 мянган төгрөгийн 7 зөрчил² илэрч албан шаардлага хүргүүлсэн.

3.1 Албан шаардлага

1. Нийгмийн даатгалын тайланд 178.6 мянган төгрөгийн цалинг илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Албан хаагчдын цалинг нийгмийн даатгалын тайланд нөхөн тайлагнах албан шаардлага хүргүүлсэн.

2. Ерөнхий нягтлан бодогч нь өөрийн хяналт тавих чиг үүрэгтэй албан тушаалыг хавсарч 1,960.0 мянган төгрөгийн нэмэгдэл цалин авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлж буй албан хаагчдад ажил хавсран гүйцэтгэсэн нэмэгдэл олгохгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Тайлант онд 25,014.6 мянган төгрөгийн илүү болон шөнийн цагийн нэмэгдэл болон дундаж цалинг холбогдох журмын дагуу тооцдоггүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.1-т "гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирсон цалин хөлсийг тогтоосон хугацаанд ажилтанд олгох, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр тогтоогоогүй бол хөдөлмөрийн нормыг үндэслэлтэй тогтоох, аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөж байгаа цалин хөлсний тогтолцоо, журмыг ажилтанд мэдээлэх"; 109 дүгээр зүйлийн 109.3-д "Шөнийн цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно", 109.8-д "Ажилтныг

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ээлжийн хуваарийн дагуу шөнийн цагт ажиллуулбал шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Илүү болон шөнийн цагийн нэмэгдэл болон дундаж цалинг холбогдох журмын дагуу тооцож олгож байх албан шаардлага хүргүүлсэн.

4. Тайлант онд 12 байгууллагын 168,550.4 мянган төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдэл болон хоорондын тооцоог нийлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Өглөг, авлагыг тооцоо нийлэх албан шаардлага хүргүүлсэн.

5. Няравын тайлангаарх зарлагыг галч нарын зарцуулалтын баримттай тулгахад 286 тн буюу 39,043.6 мянган төгрөгийн нүүрсний зөрүүтэй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Анхан шатны зарцуулалтад үндэслэн тайлагнаж байх албан шаардлага хүргүүлсэн.

6. Бараа материалын орлогын падаан буюу бэлтгэн нийлүүлэгчийн нэхэмжлэхийн дүнтэй нярвын тайлангаар орлогодсон нүүрсийг тулгахад 46 тн 7,330.0 мянган төгрөгийн нүүрсний анхан шатны баримтын бүрдэл буюу нэхэмжлэх, падаангүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Анхан шатны баримтын бүрдлийг хангаж байх албан шаардлага хүргүүлсэн.

7. Орлогын төлөвлөгөөг 48,734.6 мянган төгрөгөөр тасалсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" / Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны 77 дугаар тогтоолтой нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Орлогын төлөвлөгөөг биелүүлэх арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Солонго дулааны станц ААТҮГ	3	85.6	-	-	3	85.6	3	85.6	-	-	-	-
Дүн	3	85.6	-	-	3	85.6	3	85.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Солонго дулааны станц ААТҮГ	7	229.3	-	-	7	229.3	-	-	-	-	-	-
Дүн	7	229.3	-	-	7	229.3	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНА		1				1		
	НИЙТ		1				1		